



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/338

Улаанбаатар хот

“Ойгоос хуш модны самар түүж бэлтгэх,
хориглох тухай”

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 13.1.8, 38 дугаар зүйлийн 38.5-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар түүж бэлтгэхийг Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө, Мандал, Төв аймгийн Батсүмбэр, Мөнгөнморьт, Хөвсгөл аймгийн Галт, Жаргалант, Хэнтий аймгийн Батширээт, Завхан аймгийн Их Уул, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Архангай аймгийн Цэнхэр, Булган, Жаргалант зэрэг сумын тусгай хамгаалалттай газраас бусад газрын ойд зөвшөөрсүгэй.

2. Ахуйн зориулалтаар хуш модны самар түүж бэлтгэхийг Архангай аймгийн Булган, Цэнхэр, Жаргалант, Төвшрүүлэх, Хотонт, Чулуут, Их-Тамир, Тариат, Өндөр-Улаан, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан, Төв аймгийн Батсүмбэр, Мөнгөнморьт, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Хүдэр, Ерөө, Мандал, Увс аймгийн Өндөрхангай, Цагаанхайрхан, Хөвсгөл аймгийн Галт, Жаргалант, Ренчинлхүмбэ, Тариалан, Түнэл, Ханх, Улаан-Уул, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Цагааннуур, Эрдэнэбулган, Завхан аймгийн Их Уул, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт сумын нутаг болон Улаанбаатар хотын ногоон бүсийн Хандгайт, Улиастайн эх, Их, Бага Баяны амны ойд зөвшөөрсүгэй.

3. Самрын ургац маш муу болон муу байгаа Архангай аймгийн Хангай, Батцэнгэл, Эрдэнэмандал, Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Сант, Түшиг, Увс аймгийн Зүүнхангай, Завхан аймгийн Тосонцэнгэл, Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр, Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Биндэр, Дадал, Дэлгэрхаан сумын нутаг, Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг, Булган аймгийн нийт нутгийн ойн сангаас хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэхийг хориглосугай.

4. Үйлдвэрлэл болон ахуйн зориулалтаар хуш модны самрыг 2015 оны 10 дугаар сарын 01-ээс эхэлж түүж бэлтгэхийг зөвшөөрсүгэй.

5. Тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ойн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Банзрагч, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Батсансар нарт үүрэг болгосугай.

011151

6. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-166 дугаар тушаалаар батлагдсан "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам"-ын 2.14-д заасны дагуу ойн мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгүүлэхийг Сэлэнгэ, Хөвсгөл, Төв, Хэнтий, Завхан, Өвөрхангай, Архангай аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

САЙД



Н.БАТЦЭРЭГ